



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/226

Улаанбаатар хот

Заавар шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.1 дэх заалт, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн ажиллах заавар”-ыг нэгдүгээр, “Шалгалтын тэмдэглэл”-ийн загварыг хоёрдугаар, “Баримт бичиг түр хураасан, буцаан олгосон хуудас”-ны загварыг гуравдугаар, “Ярилцлага хийсэн тэмдэглэл”-ийн загварыг дөрөвдүгээр, “Оролцогчийг сонсох ажиллагааны мэдэгдэл”, “Сонсох ажиллагааны явц, үр дүнгийн талаарх тэмдэглэл”, “Сонсох ажиллагаа явуулсан тэмдэглэл”-ийн загварыг тавдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталж, 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2021 оны А/185 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


3. Тушаалын хэрэгжилтийг хангаж, бүртгэл хөтлөн хяналт тавьж ажиллахыг Зөрчил шалган шийдвэрлэх газар (Х.Бэхбат)-т, “Баримт бичиг түр хураасан, буцаан олгосон хуудас” хэвлүүлэх зардлыг байгууллагын төсвөөс гаргахыг Санхүү, хангалт үйлчилгээний газар (Ж.Солонго)-т даалгасугай.

ДАРГА

Н.УУГАНБАЯР



Гадаадын иргэн, харьяатын газрын даргын
2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн
А/22.6 тушаалын нэгдүгээр хавсралт



ГАДААДЫН ИРГЭНИЙ ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН АЖИЛЛАХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гадаадын иргэн, харьяатын газрын гадаадын иргэний хяналтын улсын байцаагч (цаашид "Хяналтын улсын байцаагч" гэх) нь гадаадын иргэний талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих хүрээнд хяналт, шалгалтыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулахдаа энэхүү зааврыг баримтална.

1.2. Хяналтын улсын байцаагч хяналт, шалгалтыг Төрийн хяналт шалгалтын тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж, хэний ч нөлөөнд үл автан хараат бус, бие даасан шийдвэр гаргаж, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан болон хяналтын улсын байцаагчийн ёс зүйн хэм, хэмжээг чанд сахин мөрдөнө.

Хоёр. Хяналт шалгалтын үе шат, нутаг дэвсгэр

2.1. Хяналт шалгалт нь дараах үе шаттай байна:

2.1.1. бэлтгэл ажлыг хангах;

2.1.2. объектын судалгааг гаргах, мэдээллийн нэгдсэн сан мэдээллийг ашиглах;

2.1.3. хяналт шалгалт явуулах;

2.1.4. үр дүнг танилцуулж, шийдвэр гаргах.

2.2. Төв болон орон нутаг дахь нэгж нь харьяалах нутаг дэвсгэртээ хяналт шалгалт явуулна.

2.3. Орон нутаг дахь нэгжийн хяналтын улсын байцаагч нь байгууллагын даргын баталсан "Боомт, орон нутаг дахь нэгжийн ажиллах журам"-д заасныг баримтлах бөгөөд хяналт шалгалт явуулахдаа энэ зааврыг мөрдөнө.

Гурав. Хяналт шалгалтын бэлтгэл ажлыг хангах

3.1. Хяналтын улсын байцаагч нь хяналт шалгалтыг явуулахдаа дараах бэлтгэл ажлыг хангана:

3.1.1. хяналт шалгалттай холбоотой мэдээ, мэдээллийг цуглуулах, шалгуулагч гадаадын иргэн, харьяалалгүй хүн, түүний уригч (цаашид "Шалгуулагч" гэх)-ийн байгаа объект, түүний орц, гарцыг судлах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, тооцоолох;

3.1.2. гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангаас хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглах мэдээллийг зөөврийн төхөөрөмжид хуулах;

3.1.3. хяналт шалгалтын үед харилцах, үйл явц болон илэрсэн зөрчлийг баримтжуулах зорилгоор богино долгионы зөөврийн станц, дуу, дуу-дүрсний бичлэг хийх техник хэрэгслийг бэлтгэх, шаардлагатай тохиолдолд уг техник хэрэгслийг ашиглах. (фото аппарат, дуу хураагуур, дрон, энгэрийн камер, камер зэрэг);

3.1.4. хяналт шалгалтыг явуулахад үүсч болох эрсдлийг тооцож, аюулгүй байдлын зааварчилгаатай танилцан, гарын үсэг зурж, шаардлагатай тохиолдолд тусгай хэрэгсэл, зөөврийн станц, гар чийдэн, хамгаалах хантаазыг бэлтгэх;

3.1.5. эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамж, албаны үнэмлэх, шалгалтын тэмдэглэл, баримт бичиг түр хураан авсан болон буцаан олгосон хуудсыг бэлтгэх;

3.1.6. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл нь холбогдох хууль тогтоомжид заасан үндэслэл бүхий эсэхийг урьдчилан нягтлах;

3.1.7. хяналт шалгалтад ашиглах тээврийн хэрэгслийн хэвийн, найдвартай байдлыг шалгах, явах зардал, маршрутыг тооцоолох;

3.1.8. албан хаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдэгийг хяналт шалгалтын үед зохих журмын дагуу өмсөх, хэрэглэх;

3.1.9. цаг агаар, улирал болон ажлын онцлог, явах маршрут зэргээс хамаарч шаардлагатай тохиолдолд энгийн хувцастай хяналт шалгалтыг явуулж болно.

3.2. Хяналтын улсын байцаагч нь баталсан удирдамжийн дагуу хяналт шалгалтыг хийж гүйцэтгэнэ. Хяналт шалгалтыг улсын хэмжээнд эсхүл тухайлсан нутаг дэвсгэрийн хүрээнд явуулж болох бөгөөд төвд байгууллагын дарга, орон нутаг дахь нэгжид тухайн газрын дарга тус тус баталж, бүртгэл хөтөлнө.

3.3. Төв нь улсын хэмжээнд зохион байгуулах, эсхүл тухайлсан нутаг дэвсгэрт хяналт шалгалт хийх удирдамж батлан харьяалах орон нутаг дахь нэгжид тухай бүр хүргүүлэн гүйцэтгүүлж болно.

3.4. Орон нутаг дахь нэгж нь хяналт шалгалтыг зохион байгуулахдаа Зөрчил шалган шийдвэрлэх газарт мэдэгдэн бүртгэлд авахуулж, мэргэжил арга зүйгээр хангагдана. Тухайн шалгалтын удирдамж, хүлээн авсан гомдол, мэдээллийг Зөрчил шалган шийдвэрлэх газарт тухай бүр урьдчилан мэдэгдэнэ.

3.5. Хяналтын улсын байцаагч нь тухайн хяналт шалгалтыг эхлэхийн өмнө шалгуулагчтай холбоотой хяналт шалгалтыг өмнө нь явуулж байсан эсэх, зөрчил гаргаж байсан эсэх талаар урьдчилан нягталж, холбогдох материалтай нь танилцаж болно.

Дөрөв. Хяналт шалгалт явуулах

4.1. Хяналт шалгалтыг хоёр буюу түүнээс дээш хяналтын улсын байцаагч хамтран явуулна. Шаардлагатай тохиолдолд удирдлагын шийдвэрээр дангаар болон бусад нэгжтэй эсхүл эрх бүхий байгууллагатай хамтран хяналт шалгалт явуулж болно.

4.2. Хяналтын улсын байцаагч нь шалгуулагч этгээдэд шууд болон харилцаа холбооны хэрэгслээр өөрийн нэр, албан тушаал болон хуулийн хүрээнд хяналт шалгалтын зорилгыг танилцуулна.

4.3. Хяналтын улсын байцаагч хяналт шалгалтын явцад дараах ажиллагааг хийж гүйцэтгэнэ:

4.3.1. хяналт шалгалт эхлэхийн өмнө шалгуулагчид албаны үнэмлэх, бүрэлдэхүүнийг танилцуулж, удирдамж, шалгалтын зорилго, хамрах хүрээг мэдэгдэнэ;

4.3.2. хяналт шалгалтын үйл ажиллагааны явц болон илэрсэн зөрчлийг баримтжуулах шаардлагатай гэж үзвэл фото зураг, эсхүл дуу, дуу-дүрсний бичлэг хийж байгаа талаараа шалгуулагчид урьдчилан мэдэгдэж, баримтаар хавсаргах;

4.3.3. гадаадын иргэн зохих ангиллын виз, оршин суух зөвшөөрөлтэй эсэхийг тодруулах, Монгол Улсад орохыг үл зөвшөөрөх үндэслэл бүхий тохиолдолд бодит байдлыг тогтоох зорилгоор шалгуулагч болон бусад холбогдох этгээдтэй ярилцлага хийх, тайлбар, баримт гаргуулах;

4.3.4. тогтоогдсон нөхцөл байдлын талаар хяналт шалгалтын тэмдэглэл үйлдэх.

4.4. Хяналтын улсын байцаагч нь шалгуулагчийн хувийн болон бодит байдлыг тогтоохоор Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 3¹.1.2-т заасан хяналт шалгалтын арга, хэлбэрийг ашиглах, эсхүл илэрхий зөрчилтэй тохиолдолд зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах зорилгоор Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.3 дугаар зүйлд зааснаар үзлэг хийж болно.

4.5. Хяналт шалгалтын явцад илрүүлсэн гадаадын иргэний зөрчилтэй баримт бичгийг тэмдэглэл үйлдэн түр хураан авч, хувийг шалгуулагч этгээдэд өгнө.

4.6. Хяналт шалгалтын явцад паспорт, түүнийг орлох баримт бичиггүй, эсхүл хэн болох нь тогтоогдохгүй байгаа гадаадын иргэнийг саатуулах арга хэмжээ авна.

4.7. Шалгалтын үед шалгуулагч нь хяналтын улсын байцаагчийн хууль ёсны шаардлагыг зориуд биелүүлээгүй, хүч хэрэглэж эсэргүүцсэн, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсон тохиолдолд Хууль зүйн сайдын 2014 оны А/90 дүгээр тушаалаар баталсан "Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний хяналтын улсын байцаагч тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх тусгай хэрэгслийг хадгалах заавар"-ын дагуу тусгай хэрэгсэл, мэх хэрэглэнэ.

4.8. Виз, зөвшөөрлийн асуудал хариуцсан нэгжээс шалгуулахаар шилжүүлсний дагуу Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл олгох, сунгуулахыг хүссэн гадаадын иргэний хүсэлт, холбогдох материалд үндэслэн хяналтын улсын байцаагч шалгалт хийж дүгнэлт үйлдэх, эсхүл илтгэх хуудсаар танилцуулан буцаан шилжүүлнэ.

4.9. Хяналтын улсын байцаагч нь Монгол Улсын харьяат болох, Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах эсэх талаарх хяналт шалгалтыг харьяатын асуудал хариуцсан нэгжийн албан хаагчийн хамт явуулж, дүгнэлт үйлдэн, буцаан шилжүүлнэ.

4.10. Хяналтын улсын байцаагч нь хяналт шалгалтын явцад Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил илрүүлсэн бол зөрчлийн холбогдогчид Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг баримталж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн хэлбэрийг хэрэглэн шийдвэр гаргана.

4.11. Хяналтын улсын байцаагч нь хяналт шалгалтын явц, илрүүлсэн зөрчил, нөхцөл байдлын талаар өөрийн харьяалах нэгжийн дарга болон хяналтын улсын ахлах байцаагчид 24 цагийн дотор биечлэн болон утсаар мэдэгдэнэ.

4.12. Хяналт улсын байцаагч нь хяналт шалгалт явуулахад хэрэв ашиг сонирхлын зөрчил үүссэн бол зөрчил үүссэн тухай мэдэгдлийг байгууллагын эрх бүхий албан тушаалтанд гаргана.

Тав. Хяналт шалгалтын үр дүнг танилцуулж, шийдвэр гаргах

5.1.Хяналт шалгалтын дүнг хяналтын улсын ахлах байцаагч, эсхүл хяналтын улсын байцаагч удирдамжид заасан хугацаанд нэгтгэж, хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгжийн даргаар уламжлуулан байгууллагын даргад илтгэх хуудсаар танилцуулна.

5.2.Хяналтын улсын байцаагч нь шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил, шалгуулагчийн шалгалтын явцад гаргасан тайлбар, холбогдох бусад бичиг баримтыг үндэслэн хуульд нийцсэн шийдвэр гаргана.

5.3.Хяналт шалгалтаар Зөрчлийн тухай хуульд заасан торгох шийтгэл оногдуулахгүй боловч Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.4, 37.1.5, 37.1.6, 37.1.9, 37.1.10, 37.1.11-т заасан үндэслэл бүрдсэн эрх зүйн зөрчлийг илрүүлсэн тохиолдолд хууль тогтоомжид заасан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.4.Хяналт шалгалтын явцад илрүүлсэн зөрчлийг харьяаллын дагуу бусад нэгжийн хяналтын улсын байцаагчид шилжүүлсэн бол шийдвэрлэсэн хяналтын улсын байцаагч гаргасан шийдвэрийнхээ талаар анх зөрчлийг илрүүлсэн нэгжид мэдэгдэж, хамтран ажиллана.

5.5.Хяналт шалгалт явуулсан тухай бүр хяналт шалгалтын объектын нэгдсэн санд баяжилт хийж, бүртгэл хөтөлнө.

Зургаа.Хяналт шалгалтын явцад үйлдэх бичиг баримт, түүний бүрдэл

6.1.Хяналт шалгалтын явцад болон хяналт шалгалтын ажиллагаа, үр дүнгийн талаар дараах бичиг баримтыг үйлдэнэ:

- 6.1.1.Удирдамж;
- 6.1.2.Шалгалт хийсэн тэмдэглэл
- 6.1.3.Ярилцлага хийсэн тэмдэглэл;
- 6.1.4.Баримт бичиг түр хураасан, буцаан олгосон хуудас;
- 6.1.5.Хяналт шалгалт хийсэн тухай илтгэх хуудас;
- 6.1.6.Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт;
- 6.1.7.Хяналтын улсын байцаагчийн албан шаардлага;
- 6.1.8.Фото зураг, дуу, дуу-дүрсний бичлэг;
- 6.1.9. Хуульд заасан бусад бичиг баримт.

6.2.Хяналт шалгалтын явцад хяналтын улсын байцаагчаас үйлдэх бичиг баримтын ерөнхий бүрдэлд уг бичиг баримт үйлдсэн огноо, дугаар, газар, хяналтын улсын байцаагчийн нэр, тэмдгийн дугаар, гарын үсэг, гарын үсгийн тайлал, шалгуулагчийн овог, нэр, хаяг, байршил, ажил эрхлэлтийн байдал, гарын үсэг, гарын үсгийн тайлал байх бөгөөд хяналтын улсын байцаагч гарын үсэг зурж, тэмдэг дарах ба хоёроос дээш хяналтын улсын байцаагч хамтран гаргах бол тус бүр гарын үсэг зурна.

6.3.Хяналт шалгалтын бичиг баримт нь албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, стандартад нийцсэн байна.

6.4.“Баримт бичиг түр хураасан, буцаан олгосон хуудас” нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн хэлбэрийн жагсаалт, загварт заасан “Эд зүйл, баримт бичгийг хураан авсан тухай” тэмдэглэлээс өөр загвартай байх бөгөөд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад ажиллагааны явцад гадаадын иргэний паспорт, түүнийг орлох баримт бичгийг хураасан болон буцаан олгосон үед хөтөлнө.

6.5.Хяналт шалгалтын илтгэх хуудсанд хяналт шалгалт хийсэн огноо, хаяг, объектын байршил, хамрагдсан гадаадын иргэний тоо, хуулийн этгээдийн мэдээлэл, шалгалтаар илэрсэн нөхцөл байдал, хяналтын улсын байцаагчийн хууль зүйн үндэслэл бүхий санал, шийдвэрийг тодорхой тусгана.

6.6.Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтэд дараах зүйлийг тусгана:

6.6.1.тэргүү хэсэгт дүгнэлтийн товч агуулга;

6.6.2.тодорхойлох хэсэгт зөрчил гаргагч гадаадын иргэний талаарх мэдээлэл, ирсэн зорилго, виз, бүртгэл, оршин суух зөвшөөрлийн талаарх баримт (паспорт болон түүнийг орлох баримт бичиг, Монгол Улсын виз, визийн ангилал, визийн байх хугацаа, иргэд харилцан визгүй зорчих хэлэлцээрийн дагуу нэвтэрсэн эсэх, эсхүл оршин суух үнэмлэх, түүний хэлбэр, төрөл, дуусах хугацаа гэх.мэт)-ыг тодорхой тусгах;

6.6.3.үндэслэх хэсэгт гадаадын иргэний гаргасан зөрчлийн талаар болон хууль зүйн үндэслэл, тогтоогдсон нөхцөл байдал, ач холбогдол бүхий мэдээлэл, нотлох баримт (илэрсэн нөхцөл байдал, зөрчилд холбогдож буй үйлдэл, түүний үндэслэл, шалтгаан)-ыг тусгах;

6.6.4.дүгнэх хэсэгт зөрчигдсөн хуулийн зүйл, хэсэг, заалт, оногдуулсан шийтгэл, хууль зүйн үндэслэл бүхий хяналтын улсын байцаагчийн санал, шийдвэр;

6.7.Гадаадын иргэнийг албадан гаргах тухай дүгнэлтэд дараах материалыг нэмэлтээр хавсаргана:

6.7.1.гадаадын иргэний паспорт, түүнийг орлох баримт бичгийн хуулбар, паспортын нүүрэн тал, зорчигчийн улсын хил нэвтрэх эрхийн баримт бичигт хийсэн тэмдэглэл (визгүй зорчдог орнуудын иргэдийн хувьд мөн адил хамаарна), хамгийн сүүлд орж ирсэн виз, эсхүл оршин суух зөвшөөрлийн мэдээлэл);

6.7.2.сонсох ажиллагааны тэмдэглэл;

6.7.3.эрх бүхий байгууллагын шийдвэрийн хуулбар (шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр болон холбогдох бусад бичиг баримт);

6.7.4.тээврийн хэрэгслийн тийз (тасалбар)-ний хуулбар.

6.8.Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт нь энэ зааврын 6.2-т заасан бүрдлээс гадна, агуулгын хувьд аливаа үйл ажиллагаа, бодит байдал, ажил хэрэг, үр дүнг тодорхойлсон хууль зүйн үндэслэл бүхий бичиг баримт бөгөөд дүгнэлт нь энэ зааврын шаардлагаас өөрөөр бичигдэж болно.

6.9.Шалгуулагч энэ зааврын 6.1-д заасан хяналт шалгалтын явцад үйлдэх бичиг баримттай танилцах, гарын үсэг зурахаас татгалзсан тохиолдолд шалтгааныг заасан тайлбарыг уг бичиг баримтад бичиж хавсаргана.

6.10.Энэ зааврын 6.1.1, 6.1.2, 6.1.4, 6.1.7-д заасан бичиг баримтын нэг хувийг шалгуулагчид өгнө.

6.11.Хяналтын улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.13 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 4.14 дүгээр зүйлд зааснаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад дуу, дуу-дүрсний бичлэг, фото зураг, дүрс бичлэг хийн илэрсэн зөрчлийг баримтжуулж материалд хавсаргаж болно.

6.12.Энэ зааварын 4.7, 4.8 дахь хэсэгт заасан Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл олгох, сунгуулах, Монгол Улсын харьяат болох, Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах эсэх талаарх хяналт шалгалтын тухай улсын байцаагчийн дүгнэлт нь мөн зааврын 6.6, 6.7-д зааснаас өөр агуулгаар бичигднэ.

6.13. Шаардлагатай тохиолдолд нэгжийн даргын зөвшөөрлөөр Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны бичиг баримтын бүрдэл, бусад нотлох баримтын хувийг дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглаж болно.

Долоо.Хяналт шалгалтын бүртгэл

7.1.Төв, орон нутаг дахь нэгж хяналт шалгалтын чиглэлээр дараах бүртгэлийг цаасан болон цахим хэлбэрээр хөтөлнө:

- 7.1.1. хяналт шалгалтын удирдамжийн;
- 7.1.2. илтгэх хуудасны;
- 7.1.3. баримт бичиг түр хураасан, буцаан олгосны;
- 7.1.4. албан шаардлагын;
- 7.1.5. гарах сануулгын;
- 7.1.6. барьцааны гэрээний;
- 7.1.7. хилээр нэвтрүүлэлгүй буцаасан иргэдийн;
- 7.1.8. хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн зөрчлийн;
- 7.1.9. зөрчлийн хэрэг нээж, хэрэг бүртгэлт хийсэн;
- 7.1.10. зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзсан шийдвэрийн;
- 7.1.11. зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлсэн;
- 7.1.12. эрх хязгаарлах арга хэмжээний;
- 7.1.13. объектын судалгаа болон хяналт шалгалт, зөрчлийн фото зураг, дуу, дуу-дүрсний бичлэгийн.

Найм.Тусгай болон бусад хэрэгслийн бүртгэл, хадгалалт, хамгаалалт

8.1.Нэг бүрийн, тээврийн хэрэгсэл албадан зогсоох, хамгаалах тусгай хэрэгсэл, энгэрийн камер, зөөврийн гар станц, зургийн аппарат, дуу хураагуур, видео камер, дрон, гар чийдэн, хантааз зэргийг хяналтын улсын байцаагч албан үүрэг гүйцэтгэхдээ ашиглалт, хадгалалт, хэвийн ажиллагааг нь өөрөө хариуцна.

8.2.Нэг бүрийн, тээврийн хэрэгсэл албадан зогсоох, хамгаалах тусгай хэрэгсэл, энгэрийн камер, зөөврийн гар станц, зургийн аппарат, дуу хураагуур, видео камер, дрон, гар чийдэн, хантааз зэргийн бүртгэлийг хяналтын улсын ахлах байцаагч хөтлөж, ашиглалт, хадгалалтад хяналт тавина.

8.3.Энэ зааврын 8.1, 8.2-т заасан тусгай хэрэгсэл, бусад эд зүйлсийг хяналт шалгалт явуулах, илэрсэн зөрчлийг баримтжуулах, зааврын 4.6-д заасан нөхцөл байдал бий болсон болон гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах ажиллагааг хэрэгжүүлэх зэргээр албан үүргээ гүйцэтгэхдээ хяналтын улсын байцаагч нь холбогдох хууль тогтоомжид заасан үндэслэлээр хэрэглэж, ашиглана.

8.4.Хяналтын улсын байцаагч албан үүрэг гүйцэтгэхдээ хэрэглэх энэ зааврын 8.1, 8.2-т заасан нэг бүрийн болон хамгаалах тусгай хэрэгсэл, энгэрийн камер, зөөврийн гар станц, гар чийдэн, хантааз, фото аппарат, дуу хураагуур, видео камер, дроныг бусдад дамжуулах, шилжүүлэхийг хориглох бөгөөд өөрийн буруугаас эвдэж гэмтээсэн, үрэгдүүлсэн тохиолдолд тухайн эд зүйлийн төлбөрийг бүрэн хариуцаж арилгана.

8.5.Хяналтын улсын байцаагч нь ажлаас чөлөөлөгдөх болон өөр ажил албан тушаалд шилжин ажиллах тохиолдолд өөрийн эзэмшиж, ашиглаж байгаа нэг бүрийн болон хамгаалах тусгай хэрэгсэл, энгэрийн камер, зөөврийн гар станц, гар чийдэн, хантааз зэргийг хяналтын улсын ахлах байцаагчид хүлээлгэн өгнө.

8.6.Хяналтын улсын байцаагч өөрийн эзэмшиж, ашиглаж байгаа энгэрийн камерыг энэ зааварт зааснаас бусад тохиолдолд албаны өрөөнд өөрийн компьютерийн өмнө байрлуулан ашиглаж болно.


Ес.Хариуцлага

9.1.Албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн төрийн болон албаны, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг задруулахгүй байх, хувийн болон бусад ашиг сонирхлын төлөө ашиглахыг хориглоно.

9.2.Хяналт шалгалтыг хуульд заасан журмын дагуу явуулаагүй, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан болон хяналтын улсын байцаагчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

-----oOo-----

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын
2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн
А/226 тушаалын хоёрдугаар хавсралт



ШАЛГАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

..... он сар.....өдөр

.....
(үйлдсэн газар)

Гадаадын иргэн, харьяатын газрын (орон нутаг дахь нэгжийн) даргын баталсан ...оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаартай удирдамжид заасны дагуу хяналтын улсын байцаагч (ахлах)нар ... оны дугаар сарын-ны өдөр ... цагтхаягт хяналт шалгалтыг хийлээ. (ашигласан техник, хэрэгслийг тодорхой бичих)

1. Шалгалтад хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэл:

.....
.....
.....
.....

2. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал:

.....
.....
.....
.....

3. Шалгасан баримт бичгийн мэдээлэл (хавсралтаар):

.....
.....
.....
.....

4. Хяналтын улсын (ахлах) байцаагчийн санал, дүгнэлт:

.....
.....
.....

5. Хяналт шалгалтын үед фото зураг, дуу, дүрсний бичлэг хийсэн эсэх:

Тийм

Үгүй

Фото зураг:..... (..... кадр)

Дуу-дүрс бичлэг:.....(.... мин сек)

6. Шалгуулагчийн санал, хүсэлт:

.....
.....
.....
.....
.....

ТЭМДЭГЛЭЛ ҮЙЛДСЭН:
ГАДААДЫН ИРГЭНИЙ ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

(НЭР)


ШАЛГУУЛСАН:
ГАДААДЫН ИРГЭН
(УРИГЧИЙГ ТӨЛӨӨЛӨГЧ)

(НЭР)

7. Шалгуулагч гарын үсэг зурахаас татгалзсан тухай тэмдэглэл:

.....
.....
.....
.....
.....

Гадаадын иргэн харьяатын газрын даргын
2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн
#226 тушаалын гуравдугаар хавсралт



БАРИМТ БИЧИГ ТҮР ХУРААСАН, БУЦААН ОЛГОСОН ХУУДАС

..... он сар.....өдөр

Дугаар

.....
(үйлдсэн газар)

1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9.2-т заасныг үндэслэн Улсын иргэн-ийн дугаартай ... ширхэг паспорт, түүнийг орлох баримт бичгийг зөрчлийг шийдвэрлэх хүртэл түр хураав.

ХУРААСАН:

Хяналтын улсын байцаагч
..... (Нэр)

ХУРААЛГАСАН:

Гадаадын иргэн (Төлөөлөгч)
..... (Нэр)

2. Баримт бичиг буцаан олгосон тухай тэмдэглэл. оны сарын-ны өдөр буцаан олгов.

БУЦААН ОЛГОСОН:


Хяналтын улсын байцаагч
..... (Нэр)

ХҮЛЭЭН АВСАН:

Гадаадын иргэн (Төлөөлөгч)
.....(Нэр)



Гадаадын иргэн, харьяатын газрын даргын
2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн
А/2.2.6 тушаалын дөрөвдүгээр хавсралт



ЯРИЛЦЛАГА ХИЙСЭН ТЭМДЭГЛЭЛ

..... он сар.....өдөр

.....
(үйлдсэн газар)

Гадаадын иргэн, харьяатын газрын гадаадын иргэний хяналтын улсын (ахлах) байцаагчби, Улсын иргэн-тэй онысарын-ны өдөр дараах ярилцлагыг хийлээ:

Шалгуулагч-д дууны, дүрсний, эсхүл дуу-дүрсний бичлэгээр ярилцлагыг бэхжүүлж байгаа эсэхийг урьдчилан мэдэгдэв.

Ярилцлагыг (орон байр)-д цаг минутад эхлэв.

Биеийн байцаалт:

1. Овог, эцгийн болон өөрийн нэр:
2. Төрсөн он, сар, өдөр, нас, хүйс:
3. Боловсрол, мэргэжил:
4. Ажил эрхлэлт:
5. Оршин суух хаяг:
6. Ял шийтгүүлж байсан эсэх:
7. Биед яваа бусад баримт бичгийн дугаар:
8. Цахим, шуудангийн хаяг, утасны дугаар:

Ярилцлага хийхэд дугаарын үнэмлэхтэй, өмгөөлөгч (хууль ёсны төлөөлөгч)-ийг оролцуулав.

Асуулт:

.....
.....

Хариулт:

.....
.....

Асуулт:

.....
.....

Хариулт:

.....
.....
гэснээр ярилцлагыгцаг минутад дуусгаж, тэмдэглэлийг танилцуулав.

Ярилцлагын тэмдэглэлд засвар оруулсан эсэх:

Тэмдэглэлд.....
.....
.....
.....засвар оруулав.


ТЭМДЭГЛЭЛ ҮЙЛДСЭН:
ГАДААДЫН ИРГЭНИЙ ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ (НЭР)

ЯРИЛЦСАН:
ГАДААДЫН ИРГЭН
(УРИГЧИЙГ ТӨЛӨӨЛӨГЧ) (НЭР)

9. Шалгуулагч гарын үсэг зурахаас татгалзсан тухай тэмдэглэл:

.....
.....
.....
.....

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын
2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн
А/2226 тушаалын тавдугаар хавсралт



ОРОЛЦОГЧИЙГ СОНСОХ АЖИЛЛАГААНЫ МЭДЭГДЭЛ

..... он сар..... өдөр

(үйлдсэн газар)

Захиргааны ерөнхий хуулиас:

1. Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах тухай шийдвэр гарахын өмнө гадаадын иргэний хяналтын улсын (ахлах) байцаагч зөрчилд холбогдсон гадаадын иргэн, харьяалалгүй хүн, уригчийн зөрчлийг шийдвэрлэж, тухайн гадаадын иргэн, харьяалалгүй хүн, эсхүл түүнийг уригч (хууль ёсны төлөөлөгч)-д захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар тайлбар, санал авах ажиллагааг сонсох ажиллагаа гэнэ.

2. Зөрчилд холбогдогч гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг, эсхүл уригч (хууль ёсны төлөөлөгч)-д сонсох ажиллагааны талаарх мэдэгдлийг хүргүүлж, оролцуулна.

3. Сонсох ажиллагааны мэдэгдлийг Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт зааснаар хүргүүлж, мөн зүйлийн 27.4 дэх хэсэгт заасан арга хэлбэрээр явуулна.

4. Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлд заасан тохиолдолд гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах тухай шийдвэр гаргахдаа сонсох ажиллагаа хийхгүй байж болно.

Сонсох ажиллагааг явуулах журам:

Сонсох ажиллагаанд зөрчилд холбогдогч гадаадын иргэн, харьяалалгүй хүн, эсхүл түүнийг уригч (хууль ёсны төлөөлөгч)-ийг оролцуулах бөгөөд эрх ашиг сонирхол нь хөндөгдөж буй гадаадын иргэнийг оролцуулж болно.

Сонсох ажиллагаа явуулах он, сар, өдөр:

Эхлэх цаг, минут:

Байрлал:

Захиргааны шийдвэр гаргах тухайн асуудлын талаарх мэдээлэл, үндэслэл:

.....
.....
.....

Захиргааны шийдвэр гаргах эрх олгогдсон хууль, захиргааны хэм хэмжээний актын зүйл, заалт:

.....
.....
.....

МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛСЭН:
ГАДААДЫН ИРГЭНИЙ ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

(НЭР)

МЭДЭГДЭЛ ХҮЛЭЭН АВСАН:
ГАДААДЫН ИРГЭН

(НЭР)

СОНСОХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ, ҮР ДҮНГИЙН ТАЛААРХ ТЭМДЭГЛЭЛ

..... он сар.....өдөр

.....
(үйлдсэн газар)

Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах тухай шийдвэр гарахын өмнөх сонсох ажиллагаа нь зөрчилд холбогдсон гадаадын иргэн, харьяалалгүй хүн, уригчийн зөрчлийг арилгуулж, тухайн гадаадын иргэн, харьяалалгүй хүн, эсхүл түүнийг уригч (хууль ёсны төлөөлөгч)-д захиргааны шийдвэр гаргах болсон үндэслэлийг танилцуулж, тэдгээрийн тайлбар, санал гаргах боломжийг хангасан байна.

1. Монгол Улсаас албадан гаргах тухай захиргааны шийдвэрийг танилцуулахад зөрчилд холбогдогч гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг, эсхүл уригч (хууль ёсны төлөөлөгч)-ийн аль нь оролцсон болох:

2. Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах тухай шийдвэр гаргахдаа Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлд заасан тохиолдолд сонсох ажиллагааг хийхгүй.

3. Сонсох ажиллагааны талаарх мэдэгдлийг хүргүүлсэн байдал:

4. Сонсох ажиллагааны мэдэгдэл хүргүүлсэн он, сар, өдөр:

5. Сонсох ажиллагаа явуулсан он, сар, өдөр:

6. Байршил:

7. Сонсох ажиллагааг явуулсан хэлбэр:

8. Сонсох ажиллагааг эхэлсэн, дууссан цаг, минут:

9. Захиргааны шийдвэр гаргах тухайн асуудлын талаарх мэдээлэл, үндэслэл:

.....
.....
.....

10. Захиргааны шийдвэр гаргах эрх олгогдсон хууль, захиргааны хэм хэмжээний актын зүйл, заалт:

.....
.....
.....

11. Монгол Улсаас албадан гаргах тухай шийдвэрийг хүлээн зөвшөөрч буй эсэх талаарх гадаадын иргэний тайлбар, санал, гарын үсэг:

Тийм

Үгүй

12. Сонсох ажиллагааны үеэр гаргасан оролцогчийн тайлбар, санал:

.....
.....
.....
.....

Оролцогчийн гарын үсэг, огноо:

(Гадаадын иргэний хяналтын улсын (ахлах) байцаагчийн бөглөх хэсэг)

Тайлбар, гаргаагүй	санал	<i>Шийдвэрийг хүлээн зөвшөөрсөн</i>
Тайлбар, гаргасан	санал	<i>Гадаадын иргэний гаргасан саналыг товч бичнэ.</i>
Хэрэв гаргасан шийдвэрт тусгасан мэдээлэл	санал бол хэрхэн эсэх	<i>Шийдвэрт тусгах шаардлагагүй. Хөдөлшгүй нотлох баримтыг үнэлсэн.</i>

Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах тухай шийдвэрийг танилцуулж, сонсох ажиллагааны талаарх тэмдэглэл хөтөлсөн:

ГАДААДЫН ИРГЭНИЙ ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

(НЭР)

Огноо:.....

СОНСОХ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

..... он сар.....өдөр

.....
(үйлдсэн газар)

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн дахь заалтад зааснаар Улсын иргэн таныг Монгол Улсаас албадан гаргахаар шийдвэрлэсэн тул Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т заасны дагуу сонсох ажиллагааг явуулж байна.

Сонсох ажиллагааны явцад гаргасан хүсэлт буй эсэх /тийм, үгүй/

.....
.....
.....
.....
.....

ТЭМДЭГЛЭЛ ҮЙЛДСЭН:
ГАДААДЫН ИРГЭНИЙ ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ (НЭР)

СОНСОХ АЖИЛЛАГААНЫ ОРОЛЦОГЧ:
ГАДААДЫН ИРГЭН (НЭР)

Огноо:

Цаг: